

**УРАН ЗОХИОЛЫН ОРЧУУЛГА ДАХЬ
ХЭЛЗҮЙН ХУРААХ ҮЗЭГДЭЛ**

(“Малын хөлийн тоос”, “Би хаана төрөө вэ” зохиолын англи орчуулгад хийсэн ажиглалт)

Ц.Отгонсүрэн¹⁷⁸
С.Уранбаясгалан¹⁷⁹

***Abstract:** Through this article, we are touching upon the truncation in the sphere of the Economy Principle, as a kind of grammatical transformation. This study, for us, begins with the observation on the selected works: B. Altangerel's translation of “In the dust of the herds”, a short story written by S. Erdene and N. Oyun-Undraa's translation of “Where I was born”, a poetry written by B. Yavuukhulan. This transformation has been found more in the first work than the second. According to our first assumption, it might depend on the genres of stylistics in literature. So we tentatively proposed that this grammatical transformation needs more attention and detailed study as one of the translation methods.*

0. Оршил

Академич Ш.Лувсанвандан орчуулах үйл явцын талаар “Орчуулах гэдэг бол гүн бүтцээс өнгөн бүтцэд буулгаж байгаа биш, нэг өнгөн бүтцээс нөгөө өнгөн бүтцэд буулгаж байгаа хэрэг аж. ... харин өнгөн бүтцийн талаар өөр өөр тул нэгээс нь нөгөөд орчуулж болно” (Лувсанвандан.Ш, 1978:315) хэмээн тодорхойлжээ.

Орчуулга судлалд хэлзүйн элдэв хувиргалыг хэрэглэхгүйгээр нэг хэлнээс нөгөөд орчуулга хийх боломжгүй ба энэ нь орчуулах явцад эх хэлнийхээ өгүүлбэрийн тогтолцооны дагуу гадаад хэлний өгүүлбэрийн бүтцийг өөрчлөх явдал гэж үздэг.

“Аливаа орчуулга хийх, ярилцахад хамгийн түрүүнд хэлний буюу хэлзүйн бүтцийг үздэг заншил бий” (Доржготов.Н, 2003:26) бөгөөд орчуулагч Г.Аким “1.Өгүүлбэр нийлүүлэх; 2.Өгүүлбэр салгах; 3.Өгүүлбэрийн бүтцийг өөрчлөх; 4.Солих; 5.Орхих; 6.Нэмэх” (Аким.Г, 1984:37) харин Р.Гүрбазар “1.Өгүүлбэр дэх үгийн дэс дарааг өөрчлөх; 2.Өгүүлбэрийн гишүүдийн нэгийг нөгөөгөөр солих, орлуулах, шилжүүлэх; 3.Өгүүлбэрийг бүхэлд нь өөрчлөн хувиргах” (Гүрбазар.Р, 1996:3-11) зэрэг аргуудын талаар тодорхой дурджээ.

Дээр дурдсан болон бусад судлаачдын бүтээлээс үзвэл аливаа зохиолын орчуулгын судлалд үгсийн сангийн судалгаа зонхилох агаад хэлзүйн судалгаа харьцангуй цөөн гэж хэлэхэд буруудахгүй болов уу. Тэдгээрээс Д.Дашдаваа “Орчуулгын найруулга зүйн бүтэц-утга зүйн үндэс” (2010), Д.Бүрнээ Д.Энхтөр

¹⁷⁸МУИС. ШУС, ХУС-ын ИБАСТЭнхмийн багш

¹⁷⁹МУИС. ШУС, ХУС-ын “Гадаад хэлний орчуулгазүй”-н магистрант

нарын “Уламжлалт Монгол орчуулгын судлал” (2003) болон Ш.Одонтог “Орчуулгын хэл найруулгын тухай өгүүлүүд” (1996) зэрэг бүтээлүүдийг дурдаж болох ч эдгээр бүтээлүүд орчуулгын зохиолд ажиглагддаг хэлзүйн хураах үзэгдлийн талаар хөндөөгүй байна. Хэдийгээр энэхүү үзэгдлийг эрдэм шинжилгээний болон албан бичгийн найруулгад, үүнийгээ дагаад энэ төрлийн орчуулгад чамгүй хэрэглэдэг ч уран зохиолын орчуулга дахь хэрэглээний талаар судалгааны түвшинд төдийлөн авч үзээгүй байна. Тиймээс бид энэ тал дээр тодорхой хэмжээнд судлахыг зорьлоо.

0.1. Хэлзүйн хураах үзэгдэл

Хүн төрөлхтөнд байгалиас заяасан төрөлхийн шинж гэж байдаг ба тэдгээрийн нэг нь аливаа үйлийг аль болох хялбар дөт аргаар хийх гэсэн сэтгэлгээ юм. Энэхүү сэтгэлгээг хэмнэх¹⁸⁰ зарчим хэмээх томъёоллоор илэрхийлэх бөгөөд хамгийн бага ажилбараар өндөр үр дүнг үзүүлэхэд чиглэгддэг. Хэлшинжлэлийн үүднээс авч үзвэл хэлний хэмнэх зарчим (The Principle of Economy)¹⁸¹ буюу (The Economy Principle)¹⁸² нь хэлний бүх түвшин (авиазүй, бүтээвэрзүй, өгүүлбэрзүй)-д явагддаг ч эл зарчмын хүрээнд хамаарагдах хэлний хураах үзэгдэлхэл бүхэндхарилцан адилгүй аргаар илэрдэг. Тухайлбал англи хэлэнд дараах хэдэн аргаар илэрч байна. Үүнд:

- I. Хэлхэцийг дан үгээр илэрхийлэх:
 - 1) a. The **informative** lecture **impressed** all of us.
b. The lecture **gave us a lot of information** and **made a deep impression** on us.
 - 2) a. Our central teaching building is **seaward**.
b. Our central teaching building is **facing toward the sea**.
- II. Гишүүн өгүүлбэрийг нэрийн хэлхэцээр илэрхийлэх:
 - 3) a. I saw **the nurse’s arrival**.
b. I saw **that the nurse arrived**.
 - 4) a. **The professor’s cordial greeting** was reassuring.
b. **The professor greeted me in a warm and friendly way**, which made me feel at ease.
- III. Бие даасан хоёр өгүүлбэрийг нэг өгүүлбэр болгох:
 - 5) a. I said nothing, **which made him very angry**.
b. I said nothing. **That made him very angry**.
 - 6) a. I went back to the boat, **which was sent drifting to the middle of the stream**.

¹⁸⁰ -Монгол хэлэнд эл үг нь “арвилах, гамнах, сүйтгэл хэмнэх, эдлэх хэрэглэхэд ариглан хэмнэх” (Цэвэл.Я, 2015) гэсэн утгатай аж.

¹⁸¹ -Америкийн хэлшинжээч Н.Чомскийн үүсгүүр хэлзүйн онолынгол зарчмуудын нэг.

¹⁸² -Alessandra Vicentini(2003) болон Guiying Zhou (2012) нарын судлаачид ийнхүү томъёолжээ.

b. I went back to the boat. **The boat was sent drifting to the middle of the stream**” (Guiying Zhou,2012).

IV. “Тодотгол гишүүн өгүүлбэрийг үүсгэж буй зарим нэгжийг хасах:

-Үйл үгийн нэмэлт (Verb Complement) нь тодотгуулж буй нэр үгийг шууд зааж байвал тодотгол гишүүн өгүүлбэрийн холбох төлөөний нэр (Relative Pronoun) болон үйл үг (Verb/Predicate)-ийг бүхэлд нь хурааж болно.

7) a. In Japanese, the country’s name is **Dai Nihon, Land of Rising Sun.**

b. In Japanese, the country’s name is **Dai Nihon that means/is Land of Rising Sun.**

-Тодотгол гишүүн өгүүлбэр идэвхигүй хэвд байвал холбох төлөөний нэр болон гишүүн өгүүлбэрт идэвхигүй хэвийг үүсгэж буй туслах үйл үг (Auxiliary Verb) болох «TO BE»-ийг хурааж, үндсэн үйл үг (Main Verb)-ийг үлдээдэг онцлогтой.

8) a. “The Twelve Deeds of Buddha” is **the translation of a Tibetan original compiled by Ā’os-kyi ’Od-zer.**

b. “The Twelve Deeds of Buddha” is **the translation of a Tibetan original which was compiled by Ā’os-kyi ’Od-zer.**

V. Гишүүн өгүүлбэрийг залгаврын хэлхэцээр илэрхийлэх:

9) a. Nomadic people **from Siberia** began crossing the Bering Strait during the Ice Age.

b. Nomadic people **who migrated from Siberia** began crossing the Bering Strait during the Ice Age.” (Отгонсүрэн.Ц, 2014)

Дээрхи жишээ өгүүлбэрүүдийн бүтцийг харьцуулан үзвэл тухайн өгүүлбэрийн утга санааг эхний өгүүлбэр нь хоёр дахиаа илүү үнэн бодит, ойлгомжтой байдлаар илэрхийлсэн ба хамгийн бага нэгжийг хэрэглэхийг зорьсон нь харагдаж байна. Тиймээс дээрхи мэт хэлзүйн хураах үзэгдлүүдийг монгол-англи орчуулгад хэрхэн ашигласан талаар сонирхон, энэ удаагийн судалгааны ажлын хүрээнд үргэлжилсэн үгийн зохиолын төлөөлөл болгож С.Эрдэнийн “Малын хөлийн тоос” болон яруу найргийн зохиолын төлөөлөл болгож Б.Явуухулангийн “Би хаана төрөө вэ” найраглалын англи орчуулгыг сонгон, ажиглаж үзлээ.

1. “Малын хөлийн тоос” зохиолын орчуулга дахь хэлзүйн хураах үзэгдэл

Орчуулгын төрлүүд дотроос “уран зохиолын ажил нь өөр хоорондоо нарийн уялдаа холбоо бүхий задлан шинжилгээ хийх, боловсруулан нягтлах, нэгтгэн үр дүнгээ гаргах гурван үе шатаас бүрдэнэ. Үүний нэгдүгээр шатанд орчуулагч хүн эх зохиолд гадаад ба дотоод талын задлан шинжилгээ хийнэ. Гадаад талын задлан шинжилгээнд тухайн зохиол гарах үеийн нийгмийн орчин нөхцөл, түүх, соёл иргэншил, хүн ардын аж төрөх ёс, зан заншил тэргүүтэн хэрхэн тусгалаа олсныг нягтлан тодруулах ажил багтана. Харин дотоод талын задлан шинжилгээний үед эх зохиолын найруулга, хэлний элдэв

хэрэглэгдэхүүнийг үг зүй, өгүүлбэр зүй, найруулга зүйн үүднээс нарийвчлан авч үзнэ” (Гүрбазар.Р, 2013:4-5) хэмээжээ.

Бидний ажигласнаар эл зохиолд хэлзүйн хураах үзэгдэл дараах хэдэн аргаар илэрсэн байна. Үүнд:

Нэг. Тодотгол гишүүн өгүүлбэр (Adjective Clause)-ийг үүсгэж буй Wh-хэлхэц (Wh-phrase)-ийг бүхэлд нь хураах:

I. Залгаврын хэлхэц (Prepositional Phrase)-ээр:

10) а. **Хоймрын орон дээр** ... унтаж байгаа балчир хоёр хүүдээ хувь тавьж байгаа нь энэ.

b. It was for her two small children who were sleeping **on the bed [which is placed]at the back of the ger...**

Энэ өгүүлбэрт “Хойморт **байрлах** орон дээр” гэх тодотгол гишүүн өгүүлбэрийн тодотгол [~~which is placed~~]-ыг хурааж “хоймор дахь ор” хэмээн залгаврын хэлхэц [**at**]-ээр илэрхийлжээ. Энэ нь монгол хэлний залгамал бүтцийн нэгэн онцлогийг илтгэх бөгөөд харьяалахын тийн ялгалын нөхцөл нь харьяалж, хамаарахын утга илтгэхээс гадна бусад олон утга хийгээд үүргийг өөр дээрээ авдагтай шууд холбоотой юм.

II. Үргэлжлэх цагийн хэлбэрт байгаа үйл үг (V+ing)-ээр:

11) а.... **наашилж яваа** хөтөлгөө морьтой хүн үзэгдэв.

b. ... she saw a man [~~who was~~]**approaching** with a spare horse.

“**Наашилж яваа** хөтөлгөө морьтой хүн” гэх өгүүлбэрт “морьтой хүн”-ийг тодотгох үүрэгтэй тодотгол гишүүн өгүүлбэрийн Wh-хэлхэц болон BE үйл үг болох[~~who was~~] нь бүхэлдээ хураагдаж үндсэнүйл үгийг-INGхэлбэрт шуудхувиргаж[**approaching**] үлдээсэн байна.

III. Өнгөрсөн цагаар хэлбэржсэн үйл үг (V-ppII)-ээр:

12) а....**шимийн архи** аягалахад...

b. ... she poured some brandy [~~which is~~]**made** from milk into a cup and ...

Соёлын онцлогоос ихээхэн хамааралтайгаар, “**шимийн архи**” гэх үгангли хэлэнд байхгүй учир ийнхүү тайлбарлан орчуулжээ. Ингэж тайлбарлахдаа тодотгол гишүүн өгүүлбэрийг үүсгэх Wh-хэлхэц болон BE үйл үг буюу [~~which is~~]-ийг бүхэлд нь хураан үндсэн үйл үгийг нь өнгөрсөн цагт хувирган [**made**] болгожээ.

IV. Тэмдгийн хэлхэц (Adjective)-ээр:

13) а.... **ядрангуй царайтай** өвгөн гадагш гарч ирээд хэдэн мөчийн дотор амжуулав.

b. ... **the forlorn faced**old man [~~the old man who has the forlorn face~~] went out of the ger to do it.

“ядрангуй царайтай” гэхийг [~~the old man who has the forlorn face~~] гэж тодотгол гишүүн өгүүлбэрээр орчуулахын оронд “the forlorn faced old man” хэмээн нэрийн хэлхэцийн өмнө түүнийг тодотгох үүрэг бүхийгэмдэг нэр болгон товчлон хураажээ.

Хоёр. Байц гишүүн өгүүлбэр (Adverbial Clause)-ийг хураах:

I. Залгаврын хэлхэц (Prepositional Phrase)-ээр:

14) а. **Чанцал хонины гэдэс янзалж**, хажуугийн майханд тогоо дүүрэн мах чанаж авчирсанд...

б. **After disemboweling [She disemboweled]** the sheep, Chantsal boiled a large pot full of meat in a nearby tent and when she brought it ...

“Чанцал хонины гэдэс янзалж” буюу “[~~She disemboweled~~ the sheep]” гэх байц гишүүн өгүүлбэрийг хураан орчуулахдаа “Хонины гэдэс янзалсны дараа” буюу “**After disemboweling the sheep**” хэмээн залгаврын хэлхэцийг оруулж өгсөн байна.

Гурав. Өгүүлбэрийн гол гишүүдийг бүхэлд нь хураах:

I. Угтвар үг (Preposition)-ээр:

15) а. Тууварчдын зүүн жигүүрт байгаа **хундан цагаан гэр** бол Балбарынх.

б. To the left side of the herdsman's tents stood a white ger [~~which has~~] **with a whitetop** which belonged to Balbar.

“хундан цагаан гэр” гэх нэрийн хэлхэцийг “**a white ger [which has] a white top**” гэж тайлбарлан орчуулахдаа тодотгол гишүүн өгүүлбэрийг залгаврын хэлхэцээр орчуулжээ.

II. Үйлт нэр (Gerund)-ээр:

16) а. Өвгөн нь ... зөвлөгөөнд **оролцох яггүй үүрэг** авсан.

б. I have undertaken the **responsibility** of **attending /to attend** a meeting...

Монгол хэлний үйлт нэр буюу цагт нэрийг англи хэлэнд V+ing болон V+TO infinitive хэлбэртэй дүйлгэх бөгөөдэхний хэлбэр нь **of** угтвар үг (Preposition)-ийн ард байрлаж, нэр үг (Noun)-ийн үүргийг давхар гүйцэтгэх учраас хоёр дахийг бодвол илүү хураасан хэлбэр гэж үзэх талтай. Өөрөөр хэлбэл хоёр дахь нь үйл үг (Verb)-ээр хэвээр байгаа учраас хураасан хэлбэр гэж үзэх боломжгүй юм.

III. Холбоос үг (Conjunction)-ээр:

17) а. Балбараас дутуугүй сайхан **эр бөгөөд**, мулгүй цүлх байртай ажээ.

б. He was a good looking man like Balbar, **but [he was]** rather stupid.

Дээрх нийлмэл өгүүлбэрийн гол гишүүд нь ижил учраас хоёр дахь өгүүлбэрийн [~~he was~~]-ийн үүргийг хоёр өгүүлбэрийг холбосон **but** холбоос үг өөр дээрээ авч хураасан байна.

Дөрөв. Нэрийн хэлхэцийг хураах:

I. Төлөөний нэр (Pronoun)-ээр:

18) а. Нутгийн гурван харчуул ирсний **нэг нь** хижээл хүн. **Хоёр дахь нь** нягтлан бодогч. **Гурав дахь нь** улсын заан цолтой ...

b. There were three fellows from the countryside. **One [fellow]** was an old man ... **The next one** worked as an accountant. ... **The third [one]** had the title of 'Elephant of state'

Энэ өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн болох [**fellow**]-ийг дахин давтахгүйн тулд **one/ones** гэх үгээр төлөөлүүлэн хураасныг харж болохоор байна.

Тав. Угтвар үгийг хураах:

19) а. Цохиулах ээлжээ **хүлээж буй** лонх гэрийн хаяанд жирийн хэвтэх ажээ.

b. At the side of the ger was arrow of bottles all [~~in/during/while~~] **waiting** their turn.

Мөн өгүүлбэрт тодорхой, чухал үүрэггүй угтвар үгийгийнхүү хураах тохиолдол бий.

2. “Би хаана төрөө вэ” зохиолын орчуулга дахь хэлзүйн хураах үзэгдэл

Яруу найргийн зохиолоос Б.Явуухулангийн дээрхи шүлгийг сонгож, орчуулагч Н.Оюун-Ундраагийн орчуулсан англи хувилбарыг шүүн үзвэл хэлзүйн хураах үзэгдлийг илэрхийлэх дараах хэдэн арга ажиглагдаж байна. Үүнд:

Нэг. Тодотгол гишүүн өгүүлбэр (Adjective Clause)-ийг үүсгэж буй Wh-хэлхэц (Wh-

phrase)-ийг бүхэлд нь хураах:

I. Залгаврын хэлхэц (Prepositional Phrase)-ээр:

20) а. ...**Орсон** буурын шүд өвөл хангинах хоолойд...

b. ...In the gorge the teeth of the male-camel [~~that was~~] **in a rut** suffer perishing cold by the winter...

Дээрхи монгол өгүүлбэрийн **орсон буур** хэмээх холбоо үгийг тайлбарлан орчуулахад **буурыг** тодотгож буй тодотгол гишүүн өгүүлбэрийн Wh-хэлхэц (Wh-phrase) болон BE үйл үгийг хурааж, зөвхөн залгаврын хэлхэцээр илэрхийлжээ.

II. Үргэлжлэх цагийн хэлбэрт байгаа үйл үг (V+ing)-ээр:

21) а. ...Цан хүүрэг **савсаж** үүлс ороох оргилд...

b. ...At the peak wreathed in clouds [~~that was steaming~~] steaming hoarfrosts...

Хэдийгээр монгол өгүүлбэрт цагийн утгыг шууд заахгүй ч учир шалтгааны утга далд агуулагдаж буйг англи хувилбараас мэдэх бүрэн боломжтой байна.

Хоёр. Өгүүлбэрийн гол гишүүдийг бүхэлд нь хураах:

III. Угтвар үг (Preposition)-ээр:

22) a....Цасан ширхэг царцаж, мөс болох халилд...

b. At the precipice the snowflakes are frozen [~~and are changed/turned~~] to ice via congealing...

Эл өгүүлбэрт хэрвээ үйлийн эзэн хийгээд үйл үгийг бүхэлд нь оруулсан бол утга тодорхой байсан ч эл үүргийг уул үйл үгийн шаарддаг угтвар үг авч утгыг төгс гаргах боломжтой болгож байна. Гагцхүү ямар угтвар үг вэ гэдэг асуудал нь тухайн үйл үгээс нэлээн хамааралтайг эндээс харж болно.

IV. Үйлт нэр (Gerund)-ээр:

23) a. ...Зуун түмэн үед монгол хүний **идээшсэн**...

b. ...Where Mongolians have been accustomed to **living for** hundreds years in...

To угтвар үгийн ард байрласан үйл үгийг **-ing** хэлбэрээр хувиргасан нь тухайн үйл үгийг нэршүүлж буй хэрэг бөгөөд энэ тохиолдолд цагийн утгыг илэрхийлэхгүй.

V. Өгүүлэгдэхүүн болон өгүүлэхүүн (Sub + Verb)-ийг шууд

24) a. ...Тэнгэрийн салхинаас бусдыг **дээрээ гаргаж үзээгүй**...

b. ...That have never been mounted on by anybody but [~~that have never been mounted on by~~] the wind of the sky...

Дээрх өгүүлбэрийн холбоос үг **but** нь өгүүлэгдэхүүн болон өгүүлэхүүн [~~that have never been mounted on by~~]-ий үүргийг өөр дээрээ давхар авч хураасан байна.

Гурав. Угтвар үг (Preposition)-ийг хураах:

25) a. Хөх манхан тэнгэрийг **эзэгнэнхэн** төрлөө би...

b. I was born [~~in~~] reigning overthe clear sky of deepest blue...

Эл өгүүлбэрийн **V-ing**хэлбэр нь тухайн үйлийн байдлыг зааж буй учир түүнийг илтгэх угтвар үг **in**-ийг хурааж, үйл үгийгхураасан байна.

Дээрхи мэт хураах үзэгдэл яруу найргийн зохиолд цөөхөн тохиолдож байгаа учрыг “Хэрэв яруу найргийг үргэлжилсэн үгийн уран зохиолд тавьдаг шаардлагын дагуу орчуулаад байвал мэдээллийг цухас төдий дурдсан, утга

санаа балархай, эмх цэгцгүй өгүүлбэрийн хэлхээ болон хувирдаг” (Баясгалан.С, 1986:49) гэж өгүүлснээр тайлбарлаж болох юм.

Яруу найргийн орчуулга нь уран зохиолын бусад төрөл, зүйлийн орчуулгаас нэлээд онцгой, чухал байр суурийг эзэлдэг гэдгийг орчуулагч хэн бүхэн мэднэ. Тэр дундаа орчуулагч бид өөрсдийн яруу найргийн өвөрмөц хөг аялгуу, хэлбэр бүтэц болон дүр дүрслэлийг тэр хэвээр нь орчуулан бусдад түгээснээр монгол яруу найраг дэлхийн тавцанд гарахад маш чухал үүрэг гүйцэтгэх болно.

ДҮГНЭЛТ

Бид дээрхи хоёр зохиолын англи орчуулгыг ажиглаж дараах дүгнэлтийг хийж, энэхүү өгүүллээрээ дамжуулан нэгэн саналыг дэвшүүлж байна.

1. Бидний ажигласан найруулгын хоёр гол төрөл болох үргэлжилсэн үгийн болон яруу найргийн зохиолын орчуулгыг энэ чиглэлийн судалгааны эхлэл болгон ажиглахад хэлзүйнэнэхүү үзэгдэл үргэлжилсэн үгийн зохиолд илүү хэрэглэгдэж байгаа нь мөн түүнчлэн шинжлэх ухааны болон албан бичгийн найруулга хийгээд орчуулгад нэлээд түлхүү хэрэглэгддэг зэргээс үзэхэд үргэлжилсэн үгээр бичигддэг төрлүүдэд ихээхэн хэрэглэгддэг юм байна гэсэн анхны таамаглалыг төрүүлж байна. Үүнийг яруу найргийн зохиолтой харьцуулан хүснэгтээр зэрэгцүүлэн үзүүлбэл:

Хүснэгт-1

№	Хураах арга	Малын хөлийн тоос	Би хаана төрөө вэ
1.	Adjective Clause→Prepositional Phrase	+	+
2.	Adjective Clause→V-ing	+	+
3.	Adjective Clause→V-ppII	+	-
4.	Adjective Clause→Adjective phrase	+	-
5.	Adverbial Clause→Prepositional Phrase	+	-
6.	Verb→Preposition	+	+
7.	Verb→Gerund	+	+
8.	Noun→Pronoun	+	-
9.	Noun/Subject +Verb/Predicate→III	+	+
10.	Preposition→III	+	+

Энэ нь “...цаад зохиолд ямар байдал хэлбэртэйгээр найруулсанчлан найруулж, шүлгийн шад хэдэн үеэр бүтсэн, мөн тэр л тоотой яг ижил зохион байгуулалттай байх ёстой. Тэр бадаг шүлэг бас л уг эх шүлгийн бадаг шадын хэмжээтэй яг адил байх хуультай” (Доржготов.Н, 2003:43) гэсэн ёсоор л хэлзүйн хураах үзэгдлийг яруу найргийн зохиолд хэрэглэдэг бололтой. Мөн яруу найргийн зохиолд “үг бүрийг санасны зоргоор чөлөөтэй хэрэглэх боломж бага байдаг” (Аким.Г, 1984:90) гэдэгчлэн үргэлжилсэн үгийн зохиолыг бодвол харьцангуй цөөн хэрэглэгддэг аж.

2. Гэхдээ зөвхөн эл хоёр зохиолоор хязгаарлалгүйгээр ажиглаж үзвэл хэлзүйн хураах үзэгдэл нь илүү олон арга, хэлбэрээр илэрч болохыг анхаарах чухалтай.

3. Хэлзүйн хураах үзэгдэл аль ч хэлэнд байдаг үзэгдэл. Орчуулгад ч бас чамгүй хэрэглэдэгийг бид дээрхи хоёр зохиолын англи орчуулгын жишээгээр харуулсан гэж үзэж болно. Тиймээс энэхүү үзэгдлийг орчуулгын бас нэгэн арга талаас нь хандаж, цаашид гүнзгийрүүлэн судалбал ямар вэ гэсэн саналыг дэвшүүлж байна.

НОМЗҮЙ

1. Аким.Г.1984. *Орчуулгын санг уудлахад*. Улаанбаатар.
2. Alessandra Vicentini. 2003. *The Economy Principle in Language. Mots Palabras Words-3/2003*. <http://www.ledonline.it/mpw/>
3. Баясгалан.С. 1986. Яруу найраг орчуулах нь. *Орчуулах эрдэм-4*. Улаанбаатар.
4. Бүрнээ.Д, Энхтөр.Д.2003.*Уламжлалт монгол орчуулгын судлалд*. Улаанбаатар.
5. Guiying Zhou. 2012. *On the Embodiment of Economy Principle in the English Language. English Language and Literature Studies. Vol.2, No2*. www.ccsenet.org/ells
6. Гүрбазар.Р. 1996. *Орчуулгын онол, дадлагын үндэс*. Улаанбаатар.
7. Гүрбазар.Р. 2013. Уран зохиолын орчуулгын ажлын үе шатны асуудал. *Орчуулах эрдэм-1*. Улаанбаатар.
8. Дашдаваа.Д. 2010. *Орчуулгын найруулга зүйн бүтэц-утга зүйн үндэс*. Улаанбаатар.
9. Доржготов.Н.2003. *Орчуулга дахь хэлбэр, агуулгын шүтэлцээ*. Докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. Улаанбаатар.
10. Лувсанвандан.Ш. 2010 (1978).Хэлний өнгөн бүтэц, гүн бүтцийн тухай асуудалд. *Монгол хэлний үгүүлбэрийн судлал. Шадавын Лувсанванданы бүтээлийн чуулган. VII боть*. Улаанбаатар.
11. Одонтөр.Ш. 1996. *Орчуулгын хэл найруулгын тухай өгүүлүүд*. Улаанбаатар.
12. *Орчуулга зүй-1*. 2013. Улаанбаатар.
13. *Орчуулга зүй-2*.2013. Улаанбаатар.
14. *Орчуулга зүй-3*. 2014. Улаанбаатар.
15. *Орчуулга зүй-4*. 2015. Улаанбаатар.

16. Отгонсүрэн.Ц. Харьцаа заасан нэгж өгүүлбэрийн гишүүдийг хураах хэрэглүүр болох нь. (Англи-Монгол хэлний жишээн дээр). МУИС. МСХүрээлэн. “*Acta Mongolica*” ЭШ-ний сэтгүүл. Улаанбаатар. 2014. Vol 15. (411). 111-127-р тал
17. Оюун-Ундраа.Н. 2008. *Сувдан дуслын хэлхээс-3*. Улаанбаатар. Golden Eye ХХК.